



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ
ГАРГАХ

АУДИТЫН КОД: СБА-2024/15-ШТА-НА

Баруун-Урт хот 2024 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа
Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа
Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Оюунболд
Утас: 70512127 Цахим хаяг: Oyunboldg@audit.gov.mn
Аудитор О.Барчидгүнсэн
Утас: 70512127 Цахим хаяг: Barchidgunseno@audit.gov.mn
Аудитор Ө.Золзаяа
Утас: 70512127 Цахим хаяг: Zolzayau@audit.gov.mn
Аудитор Б.Мөнхбамбар
Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХЭСГИЙН ХОРООНЫ ТООТОЙ УЯЛДУУЛАН, ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛЖЭЭ.....	4
1.1. Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэлийн ерөнхий газар, цагдаагийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль болон журмын дагуу хуваарилсан байна.....	4
БҮЛЭГ 2. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.	5
1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.....	5
ДҮГНЭЛТ: 6	
Зөвлөмж: 6	
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	7

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их Хурал

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийв.
Аудитын зорилт	Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: - Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх - Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн газар, аймгийн Цагдаагийн газрыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор О.Барчидгүнсэн, Б.Мөнхбамбар, Ө.Золзаяа нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХЭСГИЙН ХОРООНЫ ТООТОЙ УЯЛДУУЛАН, ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛЖЭЭ.

1.1. Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэлийн ерөнхий газар, цагдаагийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль, журмын дагуу хуваарилсан байна.

1.1.1 Сонгуулийг зохион байгуулах зардлыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1 дэх заалт болон Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусган, улсын төсвөөс санхүүжүүлсэн. Энэхүү зохицуулалтын хүрээнд аймгийн сонгуулийн хороо болон хэсгийн хорооны тоо, ажиллах албан хаагчийн тоонд үндэслэн 779.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод санал авах байр бэлтгэх, шуудан холбоо, бичиг хэрэг, албан хаагчдын урамшуулал, унаа, болзошгүй зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан журмын 2-р хавсралтын 2.3 дахь заалт болон Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн зааварчилгааны дагуу дараах байдлаар төсөв хуваарилсан байна.

Хүснэгт №1

Д/д	Сумдын нэр	Дарга, гишүүн, даамлын тоо	Хэсгийн тоо	Олгосон санхүүжилт
1	Асгат	38	4	37.5
2	Баяндэлгэр	54	6	53.9
3	Дарьганга	40	4	39.5
4	Мөнххаан	50	5	48.8
5	Наран	30	3	29.2
6	Онгон	46	5	45.0
7	Сүхбаатар	46	5	45.9
8	Түвшинширээ	46	5	45.6
9	Түмэнцогт	38	4	37.0
10	Уулбаян	46	5	45.9
11	Халзан	38	4	37.8
12	Эрдэнэцагаан	70	8	69.4
13	Баруун-Урт	99	9	93.0
	Нийт дүн	641	67	628.4

Нийт олгосон санхүүжилтийн 80.7 хувь буюу 628.4 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороонд хуваарилсан байна.

1.1.3. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2¹, 10.3²-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Улсын бүртгэлийн газарт 64.8 сая төгрөг, Цагдаагийн газарт 50.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

¹ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

² Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

БҮЛЭГ 2. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.

1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

1.2.1. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 779.0 сая төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэлээр 764.1 сая төгрөгийг зарцуулж, 14.9 сая (аймгийн сонгуулийн хороо 14.8 сая, сумдын сонгуулийн хороо 0.1 сая) төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт төвлөрүүлсэн байна.

1.2.2. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор санал авах байр тохижуулах зардалд 18.7 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд цаашид ашиглах боломжтой материалыг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байна.

1.2.3. УБЕГ-ын даргын 2024 оны А/136 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 64.7 сая төгрөгийг төсөв хуваарилжээ. Үүнээс улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал, хоолны зардалд 40.1 сая, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн зардалд 5.0 сая, сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг санал авах байранд хүргэх буцаан татах зардал 7.7 сая, томилолт, сургалт сурталчилгааны зардал 11.9 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

1.2.4. Аймгийн Цагдаагийн газар хуваарилагдсан санхүүжилтээс шуудан холбооны зардалд 12.1 сая, унааны зардалд 2.0 сая, томилолтын зардалд 9.3 сая, албан хаагчдын хоолны зардалд 27.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж тайлан, судалгааг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн байна.

1.2.5. Аймгийн сонгуулийн хороонд 779.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилснаас 764.1 сая төгрөгийг дараах 17 төрлийн зардалд зарцуулсан байна. Нийт зардлын 71.7 хувь буюу 547.5 сая төгрөгийг сонгуулийн байгууллагын ажилчдын урамшуулал болон хоолны зардалд, 7.9 хувь буюу 60.8 сая төгрөгийг унааны зардалд, 6.4 хувь буюу 48.9 сая төгрөгийг саналын хуудас, төхөөрөмжийг авах, хүргэх зардалд, 14 хувь буюу 106.9 сая төгрөгийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

1.2.6. Сонгууль зохион байгуулахтай холбоотой гарсан зардлын гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв тайлагнаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт№2

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	1.1	1.1	-
2	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	18.8	18.7	0.1
3	Сургалтын зардал	32.4	31.6	0.8
4	Сурталчилгааны зардал	13.3	12.6	0.7
5	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал, НДШ-АО	549.4	547.6	1.9

6	Бичиг хэргийн зардал	11.0	11.0	-
7	Шуудан холбооны зардал	13.5	13.2	0.3
8	Унааны зардал	60.8	60.8	-
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1.3	1.3	-
10	Саналын хуудас, төхөөрөмжийг авах, хүргэх зардал	49.5	48.9	0.6
11	Сүлжээний судалгаа хийх	1.0	0.9	0.1
12	Саналын утас устгах	2.0	2.0	-
13	Шуурхай багийн зардал	3.2	1.7	1.5
14	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	2.9	2.9	-
15	Болзошгүй зардал	5.6	0.3	5.4
16	Эрчим хүчний эх үүсгэвэр ашиглах зардал	6.4	4.6	1.8
17	Санал авах байрны түлшний зардал	6.9	5.0	2.0
Дүн		779.0	764.1	14.9

1.2.7. СЕХ-ы даргын 2024 оны А/73 тоот захирамжаар 201 ширхэг зөөврийн саналын хайрцаг, 44 ширхэг ICP саналын хайрцаг, 180 ширхэг бүхээг, нийт 36.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан бөгөөд тухайн сумдын ЗДТГ-ын дансанд бүртгээгүй байна.

1.2.8 Аймгийн сонгуулийн хорооноос СЕХ-ны 2021 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3.10³-т заасны дагуу сумын сонгуулийн хороодод сонгууль зохион байгуулахтай холбогдуулан олгосон санхүүжилтийг зарцуулах зааварчилгаа боловсруулж, хүргүүлсэн байна. Мөн аймгийн Сонгуулийн хорооны гишүүд сумдын сонгуулийн хороодод хяналт шалгалт, сургалт хийх, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг холбогдох маягтын дагуу тайлагнаж хэвшсэн байна.

Зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдон шилжиж ирсэн, худалдан авсан хөрөнгө материалыг тухайн сумын ЗДТГ-ын зохих дансанд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллах

³ СЕХ нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



СҮХБААТАР АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

201 тоот, 2 давхар, Нутгийн удирдлагын ордон, 7-р баг
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас, факс: 70512024
Цахим хаяг: ssonguulinhoroo@gmail.com

2024.11.45 № 01/36
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжилт сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцалаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Холбогдох байгууллагаас ирсэн саналд тайлбар байхгүй.